

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

25/01

|                                         |                                                                                                                        |
|-----------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Огноо                                   | 2025 оны 4 сарын 25                                                                                                    |
| Цаг                                     | 15:00                                                                                                                  |
| Хурал хуралдуулах газар /хаяг, байршил/ | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр барилгын 17 давхарт |
| Хурлын хэлбэр                           | Танхим                                                                                                                 |
| Хурал зарлагч                           | Төлөөлөн Удирдах Зөвлөл                                                                                                |
| Хурлын дарга                            | Г.Уянга                                                                                                                |
| Хуралд оролцсон                         | Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, Хувьцаа эзэмшигчид, Тооллогын комиссын гишүүд                             |

“Хөвсгөл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг энэхүү хурлын дэгийн дагуу 15:00 цагт нээв.

ХУРЛЫГ НЭЭСЭН НЬ:

**Г.Уянга:** Өдрийн мэнд, Өнөөдрийн хурлыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 25/02 дугаартай тогтоолын дагуу Хурлын даргаар Г.Уянга би даргална. Иймд та бүхэнд өнөөдрийн хурлын дэгийг танилцуулъя. *(хурлын дэгийг танилцуулав.)* За ингээд хурлын дэгийн дагуу 2025 оны 04 сарын 25-ны өдрийн хурлын ирцийн талаар мэдээлэхийг тооллогын комиссын бүрэлдэхүүнээс хүсэж байна.

**Тооллогын комисс:** Өнөөдрийн “Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн тухай танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй нийт 86,707,294 ширхэг хувьцаанаас 86,703,798 ширхэг буюу 99.9 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

**Г.Уянга:** Энэхүү хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. ХЭХ-ийн материалыг хувьцаа эзэмшигчдэд БДК-аар дамжуулан илгээж, холбогдох журамд заасны дагуу танилцах нөхцөл боломжоор хангасан тул уншиж танилцсан байгаа гэдэгт итгэлтэй

байна. Иймд хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал тус бүрээр холбогдох танилцуулгыг хийж танилцуулъя.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал №1,2,3 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хамт тус тус танилцуулж, Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

**Ч.Ганхуяг:** Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосноор танилцуулж, уг тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг мөн танилцуулав.

Хэлэлцэх асуудал №4 Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;

**Г.Уянга:** Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хэлэлцэх асуудал №5 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

**Ч.Ганхуяг:** Компанийн 2025 оны 02 сарын 13-ны өдрийн 25-01 дугаартай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу Компани нь 2024 онд зорилтот түвшиндээ хүрч ажиллагаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хэлэлцэх асуудал №6 ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай.

**Ч.Ганхуяг:** Компанийн 2025 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав

Хэлэлцэх асуудал №7 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх тухай.

**Г.Уянга:** Компанийн одоогийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгохоор санал гаргаж, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд Ч.Ганхуяг, Б.Золбоо, П.Батбаяр, Х.Билгүүн, Бруно Рашле, Н.Эрдэнэтулга, Ч.Мөнхбат, Г.Зол-Эрдэнэ, Васа Шегрт нарыг нэр дэвшүүлж байна. Нэр дэвшигчдийн холбогдох танилцуулгыг танилцуулав.

#### АСУУЛТ, ХАРИУЛТ

Байхгүй.

## САНАЛ ХУРААЛТ

### Тооллогын комисс:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон хурлын үеэр өгсөн саналыг тус тус тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 86,703,798 ширхэг буюу 99.9 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
  - Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%
  - Татгалзсан: байхгүй
  - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Хурлаар хэлэлцсэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 86,703,798 ширхэг буюу 99.9 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
  - Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%
  - Татгалзсан: байхгүй
  - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй
3. Хурлаар хэлэлцсэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 86,703,798 ширхэг буюу 99.9 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
  - Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%
  - Татгалзсан: байхгүй
  - Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
4. Хурлаар хэлэлцсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд кумулятив аргаар санал өгснөөс хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 86,703,798 ширхэг буюу 99.9 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд Хурлаар 86,703,798 ширхгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

Нэр дэвшигч Ч.Ганхуяг

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй.

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Б.Золбоо

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч П.Батбаяр

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Х.Билгүүн

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Бруно Рашле

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Н.Эрдэнэтулга

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Ч.Мөнхбат

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Г.Зол-Эрдэнэ

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй

Нэр дэвшигч Васа Шегрт

Зөвшөөрсөн: 86,703,798 ширхэг буюу 100%

Татгалзсан: Байхгүй

Түдгэлзсэн: Байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8 дахь хэсэгт зааснаар нэр дэвшигчид Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдож, шийдвэр хүчинтэй.

Г.Уянга: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав. 1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, 2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах, 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх тухай, 4. ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох тухай асуудлууд тус дэмжигдэж шийдвэрлэгдлээ.

#### ХУРЛЫН ХААЛТ:

Г.Уянга: Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссын бүрэлдэхүүнд баярлалаа. Хурал хаалаа.

ХЯНАСАН,  
ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.ХАЛИУНГОО